



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 2/589

Хэрлэн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалтууд, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, Засгийн газрын 2014 оны Журам батлах тухай 222 дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнийн судалгааг хийх, иргэд, хуулийн этгээдээс санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн

ахлагч

Э.Мөнх-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

Нарийн бичиг

Б.Сүнгээ

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд

Б.Дарханбаатар

Хууль эрх зүйн хэлтсийн дарга

М.Шүрэнцэцэг

Хэрлэн сумын Засаг дарга

Г.Мөнх-Эрдэнэ

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Мөнхжаргал

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ц.Бат-Эрдэнэ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

М.Хишигбаяр

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга

Б.Буянбат

Хэрлэн сумын Байгаль орчны
хяналтын улсын байцаагч

2.Ажлын хэсгийг зохион байгуулалтаар хангаж, удирдлага, мэргэжил арга
зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Мөнх-Эрдэнэ/-д
даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ЧОГСОМЖАВ

